



МЭРГЭЖЛИЙН БА ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАГШИЙН СУРГАЛТЫН АЖЛЫГ БАГЦ ЦАГААР ТООЦОХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн мэргэжлийн сургалттай сургууль, политехник коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн багшийн танхимын ба танхимын бус сургалтын ажлын багц цаг тооцоход энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2 Багц цаг нь багшийн албан тушаалын зэрэглэлээс хамааруулан тухайн багшийн жилд гүйцэтгэх танхимын ба танхимын бус сургалтын цагийн жилийн ачаалал тогтоох, нэмэгдэл хөлс тооцох үндэслэл болно.
- 1.3 Сургалтын хичээлийн жил нь тэнхимд хичээллэх, үйлдвэрлэлийн дадлага хийх тус бүр 16-аас доошгүй /18-аас ихгүй/ долоо хоногтой 2 улирлаас тогтоно.
- 1.4 Онолын сургалтын хичээлийн нэг цаг /цаашид “цаг” гэх/-ийн хэмжээ 40 минут, хоёр цагийн хичээлийг дунд нь завсарлагагүйгээр 80 минутад багтаан явуулахаар сургуулийн хуваарьт тусгана.
- 1.5 Багшийн албан тушаалын зэрэглэл нь тухайн багшийн жилд гүйцэтгэх танхимын ба тахимын бус цагийн хамаарал, 1 багцад ногдох хөлсийг ялгавартай тогтоох үндэслэл болно.
- 1.6 Үндсэн цалин ба нэг багц цагийн үнэлгээ харилцан хамааралгүй байна.
- 1.7 Тухайн улирал, жилд багшид ногдох багц цагийг дараах нийлбэр илэрхийлэлээр бодно

$$Ch = \sum_{i=1}^n (Ch_i) + \sum_{j=1}^k Ch_j$$

Ch_i — тухайн хичээлээс багшид тооцогдох танхимын багц цаг

Ch_j — Тухайн ажил үйлчилгээнээс багшид тооцогдох танхимын бус сургалтын багц цаг тухайн хичээлээс багшид тооцогдох танхимын бус багц цаг

n - тухайн улирал, жилд заасан багшийн хичээлийн тоо

k - тухайн улирал, жилд багшид тооцогдох танхимын бус сургалтаар гүйцэтгэсэн ажил үйлчилгээний тоо

- 1.8 Багшийн хичээлийн жилийн сургалтын ажлын танхимын ба танхимын бус цагийн нийт ноогдол ачаалал нь 20 багц цаг байх бөгөөд албан тушаалын зэрэглэлээс нь хамааруулан дараах байдлаар тогтооно.



Ректорын 2011 оны...-р сарын ... өдрийн
... тоот тушаалын нэгдүгээр хавсралт


Албан тушаал	Танхимын сургалтын заавал биелүүлэх ноогдол багц	Танхимын бус сургалтын ноогдол багц
Ахлах багш	17	3
Багш	18	2
Дадлагажигч багш	19	1

ХОЁР.ТАНХИМЫН БАГЦ ЦАГИЙГ ТООЦОХ

- 2.1 Танхимын сургалтын цагт лекц, семинар, лаборатори, сургууль дээрх үйлдвэрлэлийн сургалт, үйлдвэрлэлийн болон төгсөлтийн өмнөх дадлага, захиргааны шийдвэрээр зөвшөөрөгдсөн секц, дугуйлангийн цаг хамрагдана.
- 2.2 Танхимын сургалтын лекц, семинар, лаборатори 36 цагийн бодит гүйцэтгэлийг, сургууль дээрх үйлдвэр сургалтын 54 цагийн бодит гүйцэтгэлийг, үйлдвэрлэлийн болон төгсөлтийн өмнөх дадлагын 72 цагийн бодит гүйцэтгэлийг тус тус нэг багц цаг гэж тооцно.
- 2.3 Багш жилийн ачааллын 40 хүртэл хувийн танхимын сургалтын ажил илүү гүйцэтгэж болох бөгөөд энэ тохиолдолд ноогдлоос давсан нэг багц цагийн үнэлгээ нь 105000 төгрөг байна.
- 2.4 Багш өөрөө хүсэлт гарган сургуулийн захиргааны зөвшөөрлөөр ноогдлын 40 хувиас илүү багц цаг гүйцэтгэсэн бол үнэлгээг 2.3 заалтын үнэлгээний 75 хувиар бодож олгоно. Багшийн ноогдлоос давсан илүү багц цаг нь сургалтын заавал биелүүлэх багц цагаас хэтрэхгүй байна.
- 2.5 Захирал, дэд захирал, салбар /тэнхим/-ийн эрхлэгч, сургалтын албаны дарга, менежер зэрэг багшлах эрхтэй удирдах албан тушаалтан үндсэн мэргэжлээрээ нэг улиралд 4, жилд 8 хүртэл багц цагийн сургалтын ажил гүйцэтгэж болох бөгөөд үнэлгээг гэрээт багшийн адилаар тооцно.
- 2.6 Багш нь салбар, тэнхимийн эрхлэгчийг хавсран гүйцэтгэсэн тохиолдолд жилд гүйцэтгэх /танхимын ба танхимын бус/ багц цагийн ажлын ачааллыг 40 хүртлэх хувиар хорогдуулан тооцно
- 2.7 Бодит гүйцэтгэлд багшийн буруугаас болж тасарсан цаг тооцогдохгүй.

ГУРАВ. ТАНХИМЫН БУС СУРГАЛТЫН БАГЦ ЦАГИЙГ ТООЦОХ

- 3.1 Танхимын бус сургалтын багц цагт шалгалт, шүүлэг, давтлага, курсын төсөл, сорилын шалгалт, график тооцооны ажил, сургалтын үйл ажиллагааг дэмжсэн



бүтээлч ажил, багшийн мэргэжлээрээ өсөн дэвжих, судалгаа арга зүй, суралцагчийг төлөвшүүлж, хөгжүүлэх ажил, үйлчилгээг хамруулж тооцно.

- 3.2 Танхимын бус сургалтын цаг нь багшийн жилийн цагийн ачааллын 15 хувь хүртэл байх ба бодит баримтад үндэслэн тооцно.
- 3.3 Танхимын бус сургалтын багц цагт тооцох ажлуудын гүйцэтгэлийг сар, улирал, хагас жил, жилээр тооцох бөгөөд ажил үйлчилгээнд оногдох нийт цаг нь 10 багц цагаас хэтрэхгүй байна.
- 3.4 Танхимын бус сургалтын 1.8-д заасан нормативт цагаас давуулан гүйцэтгэсэн багц цаг нь багшийн ажлын нэмэгдэл хөлс болон тооцогдох бөгөөд үүнд агуулагдах илүү гүйцэтгэсэн, ноогдлоос давсан нэг багц цагийн үнэлгээг 2.4 заалтаар бодож олгоно. Танхимын болон танхимын бус сургалтын цагийг хооронд нь шилжүүлэн тооцохгүй.
- 3.5 Танхимын бус сургалтын шалгалттай холбоотой ажлыг дараах байдлаар тооцно. Үүнд:

Шалгалтанд нэг бүлэгт -0,1 багц цаг

Шүүлэгт нэг ангид -0,05 багц цаг


Төгсөлтийн шалгалтын давтлагад нэг ангид – 0,15 багц цаг

Курсын болон график тооцооны ажилд нэг сурагчид – 0,01 багц цаг

Мэргэжлийн зэрэг тогтоох урьдчилсан шалгалтанд – 0,1 багц цаг

- 3.6 Танхимын бус сургалтын багц цагийг тооцохдоо дараах хүснэгт дэх үзүүлэлтийг харгалзана.

№	Үзүүлэлт	Тооцох багц цаг	Хянан баталгаажуулах албан тушаалтан
1	Эрдмийн зөвлөлөөр зөвшөөрөгдсөн, салбарын тэргүүлэх эрдэмтдийн тодорхойлолт, шүүмж авсан ном сурах бичиг бичиж хэвлүүлсэн, хамтран бичсэн	Улсын хэмжээний сурах бичиг бичсэн бол – 2 1 хүн – 1,5 2 хүн бол тус бүр – 0,6 3 хүн бол тус бүр – 0,4 3 ба түүнээс дээш хүн бол тус бүр – 0,2	Сургалтын албаны дарга
2	Гарын авлага лабораторын ажил, зааварчлага бичиж хэвлүүлсэн, хамтран бичсэн	1 хүн – 0,7 2 хүн бол тус бүр – 0,3 3 хүн бол тус бүр – 0,2 3 ба түүнээс дээш хүн бол тус бүр – 0,1	Сургалтын албаны дарга
3	Зөвлөмж, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл бичиж, нийтлүүлсэн /гадаад дотоодын эрдэм шинжилгээний бичигт/	Дотоодод - 0,3 Гадаадад – 0,5	Сургалтын албаны дарга
4	Мэргэжлийн ур чадварын шалгалт авах /нэг ангид/	0,1	Сургалтын албаны дарга
5	Мэргэжлийн сургалтын	Шинээр – 0,8	Сургалтын



	төлөвлөгөө, стандарт, боловсруулсан хөтөлбөр	Шинэчилж – 0,5	албаны дарга
6	Сэдвийн иж бүрэн боловсруулалтыг зурагт болон слайд, аудио болон видео бичлэгийн хамт хийсэн, баяжуулж, шинэчилсэн	0,3	Тэнхимийн эрхлэгч
7	Улс, хот, дүүрэг, аймгийн олимпиад, мэргэжлийн уралдаанд сурагчдаа бэлтгэж эхний байр эзэлсэн	Улсад 1- р байр 0,8 2- р байр 0,7 3- р байр 0,6 Хотод 1- р байр 0,6 2- р байр 0,5 3- р байр 0,4 Дүүрэг, аймагт 1- р байр 0,4 2- р байр 0,3 3- р байр 0,2 Сургуульд 1- р байр 0,2 2- р байр 0,1 3- р байр 0,05	Салбар, тэнхимийн эрхлэгч
8	Улс, хот, дүүргийн дүүрэг, аймгийн олимпиад, мэргэжлийн уралдаанд багш өөрөө оролцож эхний байр эзэлсэн	Улсад 1-р байр 0,8 2-р байр 0,7 3-р байр 0,6 Хотод 1-р байр 0,6 2-р байр 0,5 3-р байр 0,4 Дүүрэг, аймагт 1-р байр 0,4 2-р байр 0,3 3-р байр 0,2 Сургуульд 1-р байр 0,2 2-р байр 0,1 3-р байр 0,05	Тэнхимийн эрхлэгч
9	Суралцагчдын сурах орчинг бүрдүүлсэн байдал, кабинет эзэмшилт,/ангийн эд хогшлийн бүрэн бүтэн байдал, ангийн тохижилт/, сар бүр	0,09	Санхүү, нийгмийн ажилтан
10	Хичээлийн тестийн иж бүрэн сан бүрдүүлсэн /нэг хичээлд/, баяжуулж шинэчилсэн	0,1	Тэнхимийн эрхлэгч
11	Сургууль, оюутны зөвлөл, хамт олноос зохиосон ажил, уралдаанд анги хамт олноо удирдаж эхний 1-3 байруудад шалгарсан	0,06	Нийгмийн ажилтан

Ректорын 2011 оны ...-р сарын ... өдрийн
тоот тушаалын нэгдүгээр хавсралт

12	Сургууль, оюутны зөвлөл, хамт олноос зохиосон ажил, уралдаанд анги хамт олноо удирдаж шагналт байранд шалгарсан	0,03	Нийгмийн ажилтан
13	Дадлагын газар, лабораторийн ашиглалт, хариуцсан байдал /сар бүр/	0,1	Санхүү, нийгмийн ажилтан
14	Спорт зал, хими, физикийн лаборатори хариуцаж, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг хангасан байдал/ сар бүр/	0,06	Сургалтын албаны дарга
15	Хичээлийн иж бүрэн хөтөлбөр боловсруулсан /нэг хичээлд/	Шинэ – 0,1 Шинэчлэж – 0,08	Тэнхимийн эрхлэгч
16	Жижүүр багшийн үүрэг гүйцэтгэсэн байдал	0,05	Салбар, тэнхимийн эрхлэгч
17	Багш сургуулийн болон сургалтын үйл ажиллагааны тогтоосон чиглэлээр судалгаа шинжилгээний ажилд оролцож түүгээрээ патент авсан	1	Сургалтын албаны дарга
18	Мэргэжлийн сургалтын иж бүрэн хөтөлбөр модуль боловсруулсан	0,6	Сургалтын албаны дарга
19	Анги хамт олноо сурлага хүмүүжлийн зөрчилгүй хариуцаж ажилласан байдал /сар бүр/	0,1	Нийгмийн ажилтан
20	Тухайн жилд докторын зэрэг хамгаалсан	Бүтээлийн чөлөө авсан -0,5 Бүтээлийн чөлөө аваагүй -1	Тэнхимийн эрхлэгч
21	Бие даан мэргэжлийнхээ чиглэлээр мэргэжил боловсролоо дээшлүүлсэн байдал /баримтыг үндэслэн/	0,4	Тэнхимийн эрхлэгч
22	Сургуулийн нэр дээр төсөл хэрэгжүүлсэн байдал	1	Сургалтын албаны дарга
23	Хөндлөнгийн шалгалтаар сурлагын ахиц гарсан байдал	0,3	Сургалтын албаны дарга
24	Бичиг баримт, журнал бүртгэл хөтлөлт /сар бүр/	0,04	Тэнхимийн эрхлэгч, сургалтын албаны дарга
25	Сургалт, үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа /мастерын газар, сар бүр/	0,02	Тэнхимийн эрхлэгч
26	Сургуулийн захиргаанаас өгсөн ажил үйлчилгээ, үүрэг даалгаврыг амжилттай сайн гүйцэтгэсэн /үүрэг даалгаварын хуудас үндэслэн/	1 хүртэл	Захирал
27	Суралцагчид, багш нарын дунд	0,1	Сургалтын



	семинар, сургалт, уралдаан зохион байгуулж санаачлагатай ажилласан /сургалтын албар зөвшөөрөгдсөн/		албаны дарга
28	Эрдэм шинжилгээ онол практикийн бага хуралд илтгэл тавьж эхний байр эзэлсэн	Улсад – 0,6 Дүүрэг, аймагт - 0,4 Сургуульд: 1-р байр – 0,3 2-р байр – 0,2 3-р байр – 0,1	Тэнхимийн эрхлэгч
29	Эрдэм шинжилгээ онол практикийн бага хуралд илтгэл тавьж оролцсон	0,05	Тэнхимийн эрхлэгч
30	Үйлдвэр сургалтын хичээлээр ашигтай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, оруулсан орлогын 200 000 төгрөг тутамд	1	Санхүү
31	Мэргэжлийн дагуу ном сурах бичиг редакторласан	0,2	Тэнхимийн эрхлэгч
32	Бусад байгуулагаас зохион байгуулсан уралдаан тэмцээнд багш /бэлдүүлсэн сурагч/ шагналт байранд орсон	0,05	Тэнхимийн эрхлэгч
33	Спортын уралдаан тэмцээнд багш /бэлдүүлсэн сурагч/ шагналт байранд орсон	Улсад 1- р байр 1 2- -р байр 0,5 3- -р байр 0,25 Дүүрэг, аймагт 1- р байр 0,2 2- р байр 0,1 3- р байр 0,05 Сургуульд 1- р байр 0,1 2- р байр 0,05 3- р байр 0,02	Салбарын эрхлэгч
34	Багш оюутны хяналтын графикийг/ давтлага, зөвлөгөө өгөх, бие даалт тооцох, явцын шалгалт авах/ тогмол мөрдөж ажилласан байдал / хагас жилд/	0,1	Тэнхимийн эрхлэгч
35	Вэб-д суурилсан хичээлийн иж бүрэн электрон хавтас бүрдүүлж, сургалтанд ашигласан /нэг хичээлд/	0,3	Тэнхимийн эрхлэгч
36	Мэргэжлийн чиглэлээр иж бүрэн интерактив программ зохиож ашигласан	1	Тэнхимийн эрхлэгч
37	Багшийн иж бүрэн вэб хийсэн	0,6	Тэнхимийн эрхлэгч
38	Мэргэжлийн багийн ахлагч нарт сар, жилийн ажлын төлөвлөгөө, ажлын үр дүнг харгалзан /сар бүр/	0,2	Сургалтын албаны дарга



39	Лаборатори, дадлагын газар, кабинет байгуулсан	Шинэ – 1,5 50 хүртэл хувийг шинэчилсэн – 0,3 50-аас дээш хувийг шинэчилсэн – 0,5	Салбар, тэнхимийн эрхлэгч
----	--	--	---------------------------

ДӨРӨВ. ГЭРЭЭТ БАГШИЙН ЦАГ ТООЦОХ


- 4.1 Багш хүрэлцээгүй, өвчтэй чөлөөтэй, зэрэг зайлшгүй шаардлагатай тохиолдолд гэрээт багш авч ажиллуулж болно
 - 4.1.1 Сургуулийн захиргаа гэрээт багштай сургалтын ажил явуулах гэрээг байгуулж Ректорын тушаалаар баталгаажуулна.
 - 4.1.2 Сургалтын ажлын багц цагийг үндсэн багшийн ажлын цаг тооцох аргачлалын дагуу бодно.
 - 4.1.3 Гэрээт багшийн сургалтын ажлын нэг багц цагийн үнэлгээг эрдмийн зэрэг цолноос хамааруулан дараах хязгаарыг баримтлан гэрээнд нарийвчлан тусгаж мөрдөнө.

№	Эрдмийн зэрэг цол	Нэг багц цагийн үнэлгээ
1.	Магистр, түүнээс дээш	108 000 төгрөг хүртэл
2.	Бакалавр	103 000 төгрөг хүртэл

4.2 Урилгаар лекц унших

- 4.2.1 Гадны байгууллагад ажилладаг эрдэмтэн, судлаач, холбогдох салбарын тэргүүн туршлагатай ажилтныг урьж нэг удаагийн лекц уншуулахад олгох хөлсийг дараах байдлаар тогтооно.

№	Эрдмийн зэрэг цол	Нэг цагийн үнэлгээ
1	Шинжлэх ухааны доктор Академич Профессор Гавъяат ажилтан Зөвлөх инженер Доктор	25 000 төгрөг хүртэл
2	Дэд профессор Тэргүүлэх инженер	10 000 төгрөг хүртэл



Салбарын тэргүүний ажилтан
Магистр
3 Ахлах инженер
Бусад хүмүүс

ТАВ. БУСАД

- 5.1 Мэргэжлийн ба техникийн түвшний сургалтанд 15-25 суралцагчийг хичээлийн нэг үндсэн анги болгон тооцож, сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлийн багц цагийг багшид бүрэн олгох зарчим баримтална.
- 5.2 Лаборатори болон дадлагын хичээлийн бүлгийг 15-с багагүй суралцагчтайгаар тухайн хичээлийн онцлогийг харгалзан зохион байгуулна.
- 5.3 Мэргэжлийн ба техникийн түвшний сургалтын зарим нэг мэргэжлийн хувьд 15 ба түүнээс доош суралцагчтайгаар мэргэжлийн дадлага, лабораторийг хичээллүүлэх тохиолдолд тухайн сургуулийн захирлын зөвлөлөөр хэлэлцэн, тушаал гарган шийдвэрлэнэ.
- 5.4 Дээрхи заасан зарчмуудыг баримтлан тухайн сургуулийн анги, танхимын хүрэлцээ, хичээлийн онцлог байдал, суралцагсдын тоо зэргийг харгалзан хичээлийн хуваарийг зохицуулан гаргана.
- 5.5 Тухайн улирлын хичээлийн хуваарийг сургалт эхлэхээс 2 долоо хоногийн өмнө сургалтын албаны дарга, сургуулийн захирлаар баталгаажуулан гаргасан байна.
- 5.6 Нэг хичээлийг хэд хэдэн багш багцлан заасан тохиолдолд багшид ногдох нийт багц цагийг дээр заасан томъёо, аргачлалаар бодож, нийлбэр багц цагийг багш нарт хуваах асуудлыг багш нарын оролцоотойгоор тэнхимийн эрхлэгч шийдвэрлэнэ.
- 5.7 Салбар /тэнхим/-ын эрхлэгч сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлийг тухайн мэргэжлийн багш нарт тэнцүү хуваарилан жилийн ачаалыг гаргаж багш нэг бүрт танилцуулан зөвшөөрүүлж, сургалтын албаар баталгаажуулан мөрдөнө.
- 5.8 Танхимын ба танхимын бус сургалтын багц цагийн бодит гүйцэтгэлийг салбар /тэнхим/-ын эрхлэгч, сургалтын албаны дарга нар хянаж санхүүгийн албанд өгнө.
- 5.9 Танхимын ба танхимын бус сургалтын ажлын ногдол багц цагийг хүндэтгэх бус шалтгааны улмаас биелүүлээгүй нөхцөлд дутуу гүйцэтгэсэн багц цагийн хөлсийг тухайн цагт харгалзах хэмжээгээр багшийн цалин хөлснөөс хасаж тооцно.